

ШУУД ХУДАЛДАН АВАЛТЫН ҮНИЙН САНАЛ АВАХ  
УРИЛГА

Огноо: 2026 оны 5 дугаар сарын 19

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь гамшгийн үед ашиглах бусад хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зорилгоор шууд худалдан авалтын тендерт эрх бүхий аж ахуйн нэгжүүдийг урьж байна.

**1. Тендерийн нэр:** Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үед хэрэглэх хамгаалах хэрэгсэл /**амьсгал хамгаалах хушуувч, эмнэлгийн анхан тусламжийн иж бүрдэл, хээрийн майхан, бензин цахилгаан үүсгүүр**/ худалдан авах.

**2. Төсөвт өртөг:** 15,560,000 (арван таван сая таван зуун жаран мянга) төгрөг

**3. Тендер шалгаруулалтын хэлбэр:** Шууд худалдан авалт

**4. Тавигдах шаардлага:** Тендерт оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх боломжтой байх
- Санхүүгийн чадамжтай байх

**5. Бүрдүүлэх материал:**

- Албан хүсэлт
- Санал болгож буй барааны танилцуулга, техникийн тодорхойлолт монгол хэл дээр.
- Үнийн санал /дэлгэрэнгүй/

**6. Тендер хүлээн авах эцсийн хугацаа:** 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн, 13 цаг 30 минут хүртэл.

**7. Тендер хүлээн авах хаяг:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон доорх цахим шуудангаар албан бичгийн бүрдлийг ханган ирүүлнэ үү.

Тодруулах асуудлаар доорх утаснаас холбогдож лавлана уу.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам

**Хаяг:**

Улаанбаатар хот 15170, Чингэлтэй дүүрэг,  
Засгийн газрын II байр, /баруун жигүүр/,  
Нэгдсэн Үндэсний гудамж 5/2

**Утасны дугаар:** 51-264181

**Цахим шуудангийн хаяг:** info@mmhi.gov.mn